

**МОНГОЛЫН ЯПОН СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГИЙН
2013 ОНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ “ЯПОНЫ
ТООХОКУ БҮСИЙН СЭРГЭЭН БОСГОЛТ, ТҮҮНЭЭС
АВАХ СУРГАМЖ, ТУРШЛАГА” СЭДВИЙН ДОР
АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

“Японы Тоохоку бүсийн сэргээн босголт, түүнээс авах сургамж, туршлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2013 оны 11 дүгээр сарын 29-нд Монголын Япон судлалын нийгэмлэгээс ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Япон Улсын Элчин сайдын яамтай хамтран амжилттай зохион байгууллаа.

Тус эрдэм шинжилгээний хуралд “Тоохоку бүсийн сэргээн босголт болон Фүкүшима АЦС-ын өнөөгийн байдал” сэдвээр Япон Улсын Элчин сайдын Яамны Элчин зөвлөх Хаяаши Шиничиро мэдээлэл хийж, “Шинэ Монгол” сургуулийн гүйцэтгэх захирал П.Наранбаяр “Тоохоку бүсийн сэргээн босголтын талаарх Японы төрийн бодлого, арга хэмжээнүүд”, Элчин сайд Ж.Гөлгөө “Тоохоку бүст Японы Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засгийн арга хэмжээ”, Монгол-Японы соёл, утга зохиолын төвийн тэргүүн Д.Төмөрбаатар “Тоохоку бүсийн бүтээн байгуулалтын жишээнээс”, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургууль, доктор С.Баттулга “Байгалийн гамшиг “соёл”-ыг бүтээх явцад: Япон нийгэм дэх “гамшгийн соёл”-ын жишээн дээр”, МУИС-ийн Улаанбаатар сургууль Ц.Амгалан, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн У.Загдцэсэм нар “Оюун санааны сэргээн босголт ба урлаг, утга зохиолын шинэлэг чиг хандлага”, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургууль Д.Майсүлд “Япончуудын ертөнцийг үзэх үзэл: Ан амьтны жишээгээр” сэдвээр тус тус илтгэлээ.

Хуралд ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, МУИС, “Шинэ Монгол” сургууль, “Түншийн холбоо нийгэмлэг”-ийн япон судлаачид, эрдэмтэд, их дээд сургуулийн оюутнууд оролцлоо.

Тус эрдэм шинжилгээний хурал нь Японы соёл, сэтгэлгээний онцлог, байгаль орчиндоо хандах хандлага, байгалийн гамшгийн талаарх ойлголт, түүнийг даван туулах менежмент, Японы Зүүн хойд бүс нутгийн сэргээн босголтын өнөөгийн байдлын талаар судлаачид, олон нийтэд мэдээлэл түгээсэн ач холбогдолтой үйл явдал боллоо.

Мэдээ бэлтгэсэн: У.Загдцэсэм /ОУСХ/